



НОМЗҮЙ

- 1.Л.Хүрэлбаатар,"Огторгуйн цагаан гарди-1",Уб.,1996.
- 2.Л.Хүрэлбаатар,"Огторгуйн цагаан гарди-2",Уб.,2008.
- 3.Б.Жадамбаа,"Шүтэлцэн багцрахуйн үзэл ба хүмүүний хөгжил",Уб.,2007.
- 4.Б.Жадамбаа,"Эгоизмээс эгоизм үрүү шилжихийг монгол ухаанаар шинжихүй",Уб.,2009.
- 5.Б.Жадамбаа,"Тогтворжилт: Алив асуудалд монголын уламжлалт ертөнцийг үзэх үзлийн үүднээс хандахуй, түүний үр", "Мэдээлэл -2009",Уб., 2009.
- 6.Ш.Бира,"Их монгол улсын түүх, үзэл суртлын зарим онцлог асуудлууд",Уб.,2006.
- 7.Ш.Лувсанвандан,"Хэл,хэлэх хоёрын учир", "Монгол судлал" цуврал №9.
- 8.Ш.Лувсанвандан,"Хэл дохионы тогтолцоо болох нь", "Хэл зохиол судлал" №10.
- 9.Ч.Чимигбаатар, "Ш.Лувсанвандан ба 20-р зууны монголын хэл шинжлэлийн сэтгэлгээний зарим асуудал", Уб., 2001.
- 10."Монголын нууц товчоо", дөрөв дэх удаагийн хэвлэл,(хуучин монгол хэлнээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав.), Уб.,1990.
- 11.Б.Пүрэв-Очир, "Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим энерги, соёл хэрэглээ",7-р дэвтэр, Уб.,2009.
- 12.Б.Пүрэв-Очир,"Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ", 6-р дэвтэр, Уб., 2006.
- 13.Л.Түдэв, "Үгэн бороо", шилдэг исээнүүд, Уб.,2001.
- 14.О.Лхагва, "Хөтөч үзэл ба танин мэдэхүй", "Манай монгол" сэтгүүд,2003, №3.
- 15.О.Лхагва,"Мөнх тэнгэр бол эрдэм ухаан",Илтгэлүүдийн товчлол, Олон улсын монголч эрдэмтэн нарын 9-р их хурал, Уб.,2006.
- 16.О.Лхагва, "Их талын нүүдлийн соёлын ундарга", MONGOLICA, Vol.13(34),Уб.,2003.
- 17.Я.Цэвэл, "Монгол хэлний товч тайлбар толь", Уб., 1966.

«ОРОН» ХИЙГЭЭД «ОРШИХУЙ», «ДАЯАР» ХИЙГЭЭД «ДАЯАРШИХУЙ»

(цуврал-2)

(Үг, өгүүлбэрийн амь амьдрал, эрчим долгион, утга соёл)

Хэл бол алс холын гүрэнд аваачих агт морь юм.

(М.Саруул-Эрдэнэ, «Сонирхолтой хэл шинжлэл» номоос)

Abstract:

This time we have tried to examine the etymological and existential backgrounds, the content and form, the intensity and energy, the cultural and pragmatical use, the roles and places in contexts, the nature and quality of the nouns such as "орон", "даяар", "даяаршил", versus the verbs "оршихуй", "орогнохуй", "даялахуй", "даяаршихуй" in Mongolian language.

Several specific features are observed on the facts. The words "орон", "орогнохуй", "оршихуй" have carried a variety of meanings and used in a variety of ways. As we have observed, there are two types of features which characterize the word "орон": the word "орон" usually points the the general, common or universal features while taking place before the collocated word, and also to the specific, concrete features while taking place after the collocated word such as "гэр орон". The number and the rate of noun collocations related to the word "орон" is higher in literary genre. But some of its (орон) abstract and connotative meanings tend to be found and kept at lexical phraseologisms derived from the word "орон". Verbal phrases and expressions derived from the "оршихуй" are

not only in a low rate of frequency but the social sphere is also interesting, in generally, they both have expressed the recognition function and the behavior of the nomadic people.

Unlike these words and their collocations, as we have identified, the verb "даяарших" and its verbal forms have not been active and used frequently, especially in literary and public genres. But at present, as we have observed, there is an obviously increased rate in the use and frequency of these noun and verbal collocations in temporary Mongolian language. A special attention is given to the collocations "даяар монгол" and "Улс даяар". They are compared to and contrasted with each other in chronological and dichronological order. As our brief analys has showed, the former one has been used and remained in the literary genre, the latter one – in a formal genre (speech). As the single word "даяар" and the collocation "даяар монгол" have been carrying on and transmitting some unique cultural messages and background colors of their own from the period of the 12th -13th centuries to our modern days, thus their meaning and form, semantic relations, their static-dynamic distinctions,



as we expect, can be explained and examined in the following two lines: firstly, "орон – орогнол – оршихуй – орчихуй", secondly, in the lines of "даяар, даялахуй – даяаршил – даяаршихуй".

1. Үг ба утгаас үүтгэн...

Монгол хэлний "орон" гэдэг нэр үг, "оршихуй", "орогнохуй" хэмээх үйл үг, "даяар" гэдэг орны нэр, "даяаршил" гэдэг нэр үг, "даялахуй", "даяаршихуй" гэдэг үйл үгийг уг гарвал, утгын орон, агуулга, хэлбэр, эрчим энерги, соёл хэрэглээ, хам бичвэр дэх үүрэгшил байршил, мөн чанар, шинж чанарын талаас нь шинжиж сонжиж үзвэл сонин содон онцлог ажиглагдаж байна.

Байгаль, нийгмийн юм үзэгдлийн оршинги ба хөдлөнгө тал, үндэстний сэтгэлгээний эерэг, сөрөг үнэлэмж, орон зайн сэтгэлгээний орчил, орон цаг, тоо чанарыг нэгдэлд нь илэрхийлсэн дээрх үгс нь нүүдэлчин монголчуудын амьдралын ухаан, ертөнцийн юм, үзэгдлийн төрөл зүйл, хэл-сэтгэхүй, харилцаа-соёл, танин мэдэхүй-сэтгэлгээ г.м. цөөнгүй асуудалтай нөхцөлдөж, олон янз утгатайгаар хэрэглэгдэж, өвөрмөц сонин утга, мэдээллийг зөөж тээсээр иржээ.

Нүүдлийн соёл иргэншилтэй, олон янз соёлын төрөл зүйлтэй монгол хүмүүн "орон" болон "даян~даяар" гэдэг үгээр, эдгээр үгийн утгын анхдагч дүрээр чухам юуг оноон тохоож, тэмдэглэж нэрлэсэн бэ?, явцуу ба өргөн утгаар хэрэглэх хэлний мэдлэгийн тал нь юунд байна?, нөгөө талаас, ертөнцийн мэдлэг, соёлын тал нь юунд оршиж байв?, эдгээр үгсийн задаргааны хэсгүүдийн (бүтээвэр, утгалбарууд нь г.м.) хэлбэр ба агуулгын тал нь ямар онцлогтой вэ? г.м. зарим зүйлийг сонирхож, ганц хоёр санаа тайлбар хэлэхийг зорив.

Монгол хүний хэл яриа, бичиг зохиолын найруулгад "Монгол орон", "эх орон", "манай орон", "Ариун Бумбын орон", "Арилсан бурхад дагшидын орон", "Шамбалын орон", "эрлэг тамын орон", "үлгэрийн орон", "бага таван ухааны орон", "их тооны орон", "ертөнцийн нэгдмэл орон", "сэтгэлийн орон", "ухамсрын орон", "торсион орон", "соронзон орон", "хаалттай орон зай", "цахилгаан соронзон орон", "хатуу биетийн орон", "үг, өгүүлбэрийн утгын орон" г.м. нийлэмж үгс давтамж ихтэй, ер тэгээд эх бичвэрт, гол төлөв байгаль, нийгэм, соёлын зүйлтэй холбоотой тийм "үйл явдал", "хэрэг явдал"-ыг заан нэрлэх утгатайгаар хэрэглэгдэж ирсэн нь монгол хүн "орон" гэдгийг огторгуй-хугацаа, тоо чанар буюу хэлбэрээр нь ялган, мөн чанар, шинж чанараар нь ухаарч байсныг гэрчилж байна.

Гэтэл "орон зай", "орон байр", "орон зааг", "сүнс орон", "орон нутаг", "орон шавдаг", "орон сууц", "орон гэр", "орон дэлхий", "орон овоохой", "гэр орон", "газар орон", "нутаг орон", "орон суурин", "сансар орон", "орон оромж", "орон шорон", "орон тоо", "сул орон тоо", "орон даяар" г.м. хүн ба амьтны орогнон оршихуй, байршихуйн хэлбэр, нийгэм-соёлын орон зайн хэсэг ба бүхэл, бодтой ба хийсвэр, тусгай ба ерөнхийн утгыг заадаг арга билгийн шинжтэй

хоршоо үгс буюу зэрэгцээ үгс бүр ч их давтамжтай хэрэглэгдсээр ирснийг утгазохиолын хэлний жишээ баримтаар хялбар нотолж болно. Энд сонирхол татах зүйл бол "орон" гэдэг үг нь өмнөө орж, ерөнхий шинжийг заах, "гэр орон" гэсэн байдлаар хойно нь орж, тусгай, тодорхой шинжийг заах тийм хоёр хэв шинж ажиглагдана.

Тэгтэл бас "ор мөргүй", "огт-ор-гүй...", "газарт оргүй, усанд чилмийгүй", "орох орон, оочих аягагүй", "газрын орны дагина, тэнгэрийн орны хүү..." г.м. тогтвортой хэвшмэл хэллэгт "оршихуй"-н ямар нэг хэр хэмжээний хийсвэр, шилжсэн, салаалсан утга хадгалагдаж байхад, орших, ил (далд) орших, орогнох, оршин хувисах, оршин байх, оршин тогтнох, оршин шүглэх, орон зайгаа олох, ...биед.... оршин шингэхүй г.м. үйл хэллэг, хэлцүүд харьцангуй давтамж багатай ч, хэрэглэгдэх социал хүрээ нь сонирхолтой, ер нь нүүдэлчдийн танихуйн зан үйлийг нь илтгэсэн байдаг.

Нөгөө талаас, дээр өгүүлсэн "орон", "орон зай" г.м. үг, түүний салаа олон утгатай зэрэгцээд л, "даяар монгол", "даяар ертөнц", "даян дэлхий", "даян аварга", "Даян дээрх (хийд ба дуудлага)", "Батмөнх даян хаан", "дэлхийн дайд буюу даяд", "улс даяар", "хотол даяар", "дэлхий даяар", "энэхэн дэлхий даяхнаараа..." г.м. нэр нийлэмжүүд, тэрчлэн "даялах", "даяарших", "даяых~доёых", "даясхийх ~ доёсхийх" г.м. үйл үгийн хэлбэрүүд нь төдий л идэвхтэй бус, давтамж багатай хэрэглэгддэг ч энд "даяар"-тай нийлэмжүүд нь огторгуй- хугацаа (space-time)-ны "даялах", "муруйх" утгыг монгол хүмүүн ухаарч байсныг илтгэсэн мэт санагдана.

Монгол хэлний найруулгын гол төрөл жанруудаас ярианы, уранзохиолын, сонин нийтлэлийн найруулгад нөгөө "орон" гэдэг үг нь "этүгэн", "өтөг", "нутаг", "байр", "газар", "дэлхий", "зай~зайц", "ертөнц", "савдаг" г.м. үгстэй ойролцоо утгын оронд гол төлөв байгаль, ертөнцийн төрөл зүйлд хамаатай юмыг зааж, хэрэглэгдэж ирсэн байхад, харин нөгөө "даяар" гэдэг хэлбэр нь хуучин уранзохиол, бичиг нийтлэлийн найруулгад тун ховор, хааяа нэгхэн Монгол ардын урт дууны үгэнд: "Гоёхон замбативийн нар нь энэхэн дэлхий даяхнаар аа...", түүх бичлэгийн номд "Ар монгол даяар..." гэсэн хэлбэрээр тохиолдох төдий байгаа нь сонин. Харин орчин цагийн бичиг зохиолын найруулгад "даяар" гэдэг нэр үг, "даяарших" гэдэг үйл үгийн давтамж, хэрэглээ мэдэгдэхүйц өссөн байгаа нь олон эшт үзэлтэй холбоотой байж болох. Жишээлбэл үүнийг "Даян дэлхийд энх тайвныг тогтоох..." гэдэг хэллэг, "Даяар монгол" гэдэг сонин нэрээс наашлуулаад, олон баримтаар баталж болно. Нэг баримт татаж харья л даа: ЮНЕСКО болон "Вашингтон пост" сонин улирч байгаа мянганы түүхэн хүнээр Чингис хааныг тодруулсныхаа үндэслэлийг: "Өнгөрсөн мянган жилд гарсан хамгийн том үйл явдал бол цэвэр нэг л үндэстэн дэлхий даяар сүр хүчээ бүрэн төгс илтгэж чадсан явдал бөлгөө... Тэр (Чингис хаан) болон түүнийг залгамжлагчид Европ-Ази тивийг хамарсан чөлөөт худалдааны асар өргөн соёл иргэншлийн хэлхээ холбоог бэхжүүлж өгсөн юм. Үүнийг дундад



зууны үеийн ГАТТ-ын тогтолцоо байсан гэж хэлж болно... Тэд интернет бүрэлдэхээс аль тэртээх 700 жилийн өмнө дэлхийг холбосон харилцаа холбооны сүлжээг анх бий болгосон байна. Тэрээр (Чингис хаан) хүн хүч, шинэ арга технологийг сүлжилдүүлэн, дэлхий ертөнцийг ойртуулж нягтруулсан хүн... хэмээн 1995 оны 12 сарын 31-ний дугаартаа тодорхойлжээ. (Ц.Минжин, “Их засаг”, түүх, эрхзүйн шинжилгээ, ред.акад.Ц.Нарангэрэл номоос дам авав). Сүүлийн жилүүдэд зах зээлийн харилцааны нэртөмьёо гэдэг нэрийн дор гол төлөв американизм авч, тэр чигээр нь “зажлахгүй залгидаг” залуус, тэдэн дотор улс төрчид, сэтгүүлчид олширсоор байна. **Даяаршиж** байгаагийн улмаас гэж түүнийгээ өмөөрөх бэлэн бамбай ч бас бий. (Л.Түдэв, “Хэлний дарангуйлал”-аас) г.м. Энд буй “дэлхий даяар”... “**даяаршиж буй...**” гэх зэрэг жишээ баримт бол ардчилсан тогтолцооны орчин дахь хэвлэл нийтлэлийн жишээ баримт бөгөөд “**даяар**”, “**даяаршил**”, “**даяарших**” гэдэг үгийн хэрэглээний орчин, өнгө аяс нь социал шинжээрээ өөр болж байгааг илтгэж буй хэрэг болно.

Гэтэл харин хуучин тогтолцооны үед, үзэл сурталд ихэд хүлэгдсэн, хэвлэл утга зохиол хатуу хяналттай байсан тэр үед буюу одоогоос 60 жилийн тэртээ эрдэмтэн-зохиолч Ц.Дамдинсүрэн анх түрүүнд “**БНМАУ-ын шинэ сүлд дуулал**”-ын үгэнд:

Дархан манай хувьсгалт улс

Даяар Монголын ариун голомт

Дайсны хөлд хэзээ ч орохгүй.

Дандаа энхжин үүрд мөнхөжнө... гэж шүлэглэсэн бөгөөд урансайхны найруулгад “**даяар Монгол**” гэсэн даяартай нийлэмжийг хэрэглэхдээ найруулгазүйн утгын хувьд, “**голомт**” гэдэг үгийг урансайхны орон зайн утгын төвд тавьж, харин “**даяар**”-тай нийлэмжийг нэг голомтоос салбарлан цэг цэгт түгсэн гэсэн утгаар нь “**нийт Монголын**”, “**хүйн холбоотой Хамаг монголын** (P.S: энд бид “**хүйн холбоо**” гэдгийг хийсвэр утгаар нь, орон зай, цаг хугацаа, тоо чанарын нэгдэлтэй гэж үзсэн билээ.), “**Чингисийн Монголын**” гэсэн тийм үлэмж өргөн, энэ дэлхийн даяхнаар, олон соёлын орчил, нэгдмэл ертөнцөд түгсэн гэсэн тийм утгаар хэрэглэжээ гэж үзэж болмоор санагдана.

Өөр нэгэн зүйл бол “**БНМАУ-ын Улсын шинэ сүлд дууллыг батлах тухай**” БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1950.IV.26-ны өдрийн зарлигт:

Ардын хувьсгалын жилүүдэд БНМАУ-ын байдалд гарсан хувьсгалт өөрчлөлтүүдийг харгалзаж, Улсын Бага хурлын тэргүүлэгчдээс тогтоох нь:

1. Үгийг Ц.Дамдинсүрэн зохиож, хөгжмийг Л.Мөрдорж, Б.Дамдинсүрэн нар оруулсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын шинэ сүлд дууллыг баталсугай.

2. БНМАУ-ын шинэ сүлд дууллыг 1950 оны 5-р сарын 1-нээс эхлэн **улс даяар дуулж хэрэглэсүгэй.** гэж заасан байдаг бөгөөд энэхүү зарлигийн “**Улс даяар**” гэдэг нийлэмж үгэнд “**даяар**”-ыг өвөрмөц байранд, нөгөө “**даяар Монгол**” гэдгээс нь өөр хязгаарлагдмал

орон зайн утгаар найруулж хэрэглэсэн байдаг нь сонин тохиолдол юм аа.

Сүлд дууны шүлэг ба түүнийг дуулж хэрэглэх тухай зарлиг гэсэн хоёр баримтад байгаа “**Даяар Монгол**”-ын “**даяар**” нь ямар утга онцлогтой вэ?, нөгөө “**Улс даяар**”-ын “**даяар**” нь бас ямар утга, үүрэг, онцлогтой вэ гэдэг нь өгүүлэгч ба бичигчийн найруулах эрдэм, тэрхүү мэдээллийг хүртэн хүлээн авагчийн туршлага, эх бичвэрт мэдлэг ба мэдээллийг өгүүлж буй төсөөлж ойлгосон дүр төрх, найруулгын тавил, соёлын орон зай, үгийн утгын өнгө аяс, өгүүлэгчийн бодит ба хийсвэр үнэлэмж, баймж, тухайн бичил эхийн гол санаа, зорьсон санаа, шургуулсан санаа зэрэг олон асуудалтай холбоотой байж болох.

2. “Орон”, “даяар” хоёр нь...

Монгол хэлний энэ хоёр үгийн утгыг толь бичгийн утгаар ойлгох, нэртөмьёоны болон нэртөмьёоны бус утгаар ойлгож хэрэглэх, тэрчлэн физик биет, түүний гадаргууг тойрсон орон зай, хязгаар мужлал хэмээх утгаас нь авч үзэх, бас нүүдэлчин монголчуудаас “**орон**”, “**зай**”, “**даяар**” г.м. үгсийг албан бус боловсролын хүрээнд үгийн утгын олон салаалал, хөрвөл, хэрэглээний талаас нь ойлгож мэдэрч ирсэн зэрэг нь ялгаа заагтай зүйл болно. Монгол хэлэнд ямар ч хүрээний оронг, тухайлбал, “**бурхны орон**”, “**тамын орон**”, “**утгын орон**” бүгдэд нь л ерөнхийд нь “**орон**” гэдэг ганцхан үгийг заавал дагалдуулж, эсвэл тэрхүү “**орон**” гэдэг үгийг бусад үгтэй, тухайлбал, “**орон зай**”, “**орон дэлхий**”, “**орон нутаг**”, “**гэр орон**” г.м.-ээр хоршиж, задлаг нийлэмжээр, аль эсвэл, тэрхүү “**орон**” гэдэг үгийнхээ өмнө нь ямар нэг тодотгол үг хүртээж, тухайлбал, “**эх орон**”, “**бурхны орон**”, “**тамын орон**”, “**сэтгэлийн орон**”, “**цахилгаан орон**” г.м.-ээр ялган тодруулж хэрэглэж найруулдаг нь монгол хэлний бас нэг гүн ухаан, өвөрмөц онцлог гэмээр байдаг. Гэтэл бас орос, англи зэрэг бусад хэлэнд ч тэрхүү олон янз “**орон зай**”, “**орон**”-ы ойлголт ухагдахууныг, тухайлбал орос хэлэнд “**родина**”, “**страна**”, “**место**”, “**местонахождение**”, “**поле**”, “**пространство**” г.м.-ээр; англи хэлэнд “**homeland**”, “**country**”, “**space**”, “**space-time**”, “**open space**”, “**land**”, “**place**”, “**territory**”, “**area**”, “**province**”, “**countryside**”, “**vacancy**”, “**staff**”, “**hearth**”, “**wigwam**”, “**dwelling**”, “**paradise**”, “**gap**” гэх зэрэг өөр өөр үг хэллэгээр илэрхийлдэг ялгаа ба нийтлэг байдаг ажээ.

Ер нь ертөнцийн нэгдмэл орон зай, цаг хугацаа, түүний орчил хөдөлгөөн, харилцан үйлчлэл хэмээх ойлголт бол тодорхой энерги бүхий биетийн оршихуйн үндсэн хэлбэр бөгөөд сав ба шим ертөнцийн тодорхой масс бүхий биетүүд, түүний гадаргуу, хүрээ хаяаг бүрхсэн корпуслаг-бөөмлөг ба долгиолог шинж чанар бүхий “**орон**”-г үүсгэгч цэгүүдийн шинж чанар, тархалт, дүр, төрх, эмх цэгцгийг хөдлөнгө / зогсонги, бодтой/хийсвэр, хязгаарлагдсан/эс хязгаарлагдсан, нэмэх/хасах, ээлтэй/ ээлгүй, сайнаар орогносон/муугаар шүглэсэн, нөхөр/дайсан г.м. олон талаас нь нэрлэх, мэдээлэх, тайлахад хэл хэлэнд өөр өөр үг хэллэгээр илэрхийлэх нь хам хүрээнээс шалтгаалах,



нийгмийн социал хүрээнээс шалтгаалах, хэлийг хэрэглэгч - хүнээс шалтгаалах хэлний соёлын айн зүйл гэж үзэж байна. Тийм учраас монгол хэлэн дэх “орон” гэдэг үгийн үндсэн утга, салаалсан ба шилжсэн утгууд нь эцсийн дүндээ нөгөө л ертөнцийн нэгдмэл “орон” ~ “орон цаг”-н тухай мэдлэг, мэдээллийг л хам хүрээнд нь судалж тайлахаас ангид зүйл огт биш ажээ. Учир нь ерөөсөө “үг” бол мэдээлэл дамжуулагч дохио учраас монгол хэлний “цэг”, “ор мөр”, “орон”, “орон-цаг”, “даяар” г.м. үгс цөм ялгаагүй ямар нэг бодот ба хийсвэр утга, мэдээллийг тээж, зөөвөрлөн дамжуулсаар яваа гэж үзэж болно.

3. “Даяар монгол”, “Улс даяар” хоёр нь...

Энэхүү хоёр нийлэмжийг нэг талаар, харьцуулан, нөгөө талаар, эсрэгцүүлэн ажиглаад, үг хэллэгийн амьдрал, утга, эрчим, үүрэг, хэрэглээ, мэдээлэл тээх онцлог, соёлын талаас нь шинжилбэл бас л өвөрмөц онцлог, сонин содон ялгаа байна. “Даяар монгол” гэдэг нийлэмж нь Цэндийн Дамдинсүрэнгийн зохиосон шинэ сүлд дууллын шүлэгт буюу урансайхны найруулгад, нөгөө “Улс даяар” гэдэг нийлэмж нь БНМАУ-ын шинэ сүлд дууллыг батлах тухай БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн зарлигт буюу албан хэргийн найруулгад хэрэглэгдэж, бичигдэн үлджээ. Энэ хоёр нийлэмж үг нь бүрэлдүүлбэрүүдийнхээ байрлал, тусгай, ерөнхийн харьцаа, ялгасан, эс ялгасан ёс, хийсвэр, бодтой тал, хязгаарласан, эс хязгаарласан орон зайн утга, зөөвөрлөх тээвэрлэж ирсэн мэдээлэл зэргээрээ ялгаатай юм.

“Даяар Монголын ариун голомт...” гэдэгт “даяар” гэдэг үг нь “Монгол” гэдэг үгээ тодотгон байрласан бөгөөд ялгасан, тодруулсан тэмдэг нэрийн үүрэгтэй байгаа. Үүнээс үүдэж, “Даяар монгол...” хэмээх нийлэмжээс нь хөх толбот монголчуудын гэрэлт ертөнцийн дөрвөн зүг, найман зовхист тасралтгүй, зогсолтгүй тархсан орон зай, орчлон дэлхийгээр даялан, хуйлран эргэлдсэн тийм эрчимлэг орон-төрхөмтэй гэх утгыг байцаан хөөцөлдөж болох юм. Чингэхдээ “даяар”, “даялах”, “даяых”, “даяарших” г.м. үгсээс зөвхөн нэг зүгт тархан хуйларсан гэх утгыг бус, харин баруун тийш ч, зүүн тийш ч буюу дорно руу ч, өрнө рүү ч тархан даялан орчсон гэсэн тоо, чанарын ялгааг нь гарган хэлэлцэж болно.

Харин нөгөө “Улс даяар дуулж хэрэглэсүгэй!” гэдэгт “даяар” гэдэг үг нь “Улс” гэдэг үгээ түшин дагаж, туслах үгийн үүргээр орсон бөгөөд газарзүйн, орон зайн тодосгон ялгах утга, үүрэгтэй байгаа юм. Үүнээс үүдэж, “Улс даяар...” гэдэг нийлэмжээс хязгаарласан орон зайн утгыг зөвхөн БНМАУ-ын газрын зургаар тогтоон баталсан нутаг дэвсгэрт буюу 1.564.116 км² талбайтай орон зайд гэх үзэгдэх талбайн утгаар ойлгож болох талтай байна. Тэгэхлээр монгол хэлний “даяар” гэдэг үгийн нөгөө үгтэй харьцах харьцаанаас түүний оршинги, хөдлөнгө шинжээс, нэрших, үйлших, тэмдэгших, дайварших онцлогоос нь үүдээд, түүний орны утга нь өөр өөрөөр илэрхийлэгдэн салаалж иржээ гэж үзэв. Ингэхдээ бид монгол хэлний “орон” гэдэг үгтэй болон “даяар” гэдэг үгтэй нийлэмжүүдийн

агуулга, хэлбэр, утгын орны харьцаа, зогсонги ба хөдлөнгийн амьд шинжийг нь нэгд, **орон-орогнол-оршихуй-орчихуй** гэсэн шугамаас, хоёрт, **даяар-даялахуй-даяаршил-даяаршихуй** гэсэн шугамаас үүдүүлэн тайлбарлах нь зүйтэй юм гэж бодож байна.

Монгол хэлний “орон”, “даяар” гэсэн үг ба “Даяар Монгол”, “Улс даяар” хэмээх хоёр нийлэмжийн “утга”, “мэдээлэл” гэсэн өвөр зуураа салшгүй холбоотой хоёр зүйлийг системийн шинжилгээний аргаар задалж сонирхож үзэхэд, энэ хоёр үг ба нийлэмжийн утга, үүрэг, амьдрал, эрчим, хэрэглээ, соёлын эргэх холбооны тогтолцоо нь өвөрмөц онцлогтой зүйл бөгөөд манай монголчууд тэрхүү “даяар”, “даяаршил”, “даяаршихуй” гэдэг үг, түүний утгаар үндэстний, үндэстэн хоорондын, бүс нутгийн, нэг улс гүрний ч хэмжээнд глобал эрх ашгийг илэрхийлж чадсан төдийгүй, бас тэрхүү тогтолцооны “орж буй” зүйл болох орон зайг, “гарч буй” зүйл болох орчил хөдөлгөөнтэй нь тэмдэглэж чадсан гэж үзүүштэй санагдана. Тэгэхлээр монгол хэлний “даяар”, “даяаршил”, “даяаршихуй” гэдэг үгс үлэмж сонин эрчим энерги, үнэлэмж, утга, мэдээллийг тээж зөөж ирсэн төдийгүй өнөөгийн дэлхийчлэгдэж буй орон зайд улам давтамжтай, идэвхтэй хэрэглэгдэх боллоо. Ер, тэгээд монгол хэлний “даяар”, “даяаршил”, “даяаршихуй” г.м. үгсийн түүхэн ба эдүгээчилсэн утга, мэдээлэл, эрчим, соёлын орон зайг нь судалж нягталж үзэхүл, нөгөө латин хэлний **global** буюу бөмбөрцөг гэдэг үгээс үүсэлтэй “**Globalization**” гэдэг үүсмэл үгийг ор гарч, оготно сүүлээгүй байхад эх хэлнийхээ үг-утгын сангийн орон зайд тодорхой байртай, өвөрмөц хөгөч утга санаатай байсан байж болох үндэстэй байна. Гэвч түрүүнд ургасан чихнээс сүүлд ургасан эвэр гэдэг монгол цэцэн үг байдаг билээ. Ер тэгээд “**Глобализация**”, “**Globalization**” гэдэг үг нь өдгөө соёл иргэншлийн орон зайд үлэмж идэвхтэй түрж байгаа бөгөөд эдгээр харь хэлний үгийг монгол хэлний “**даяаршил**” гэдэг үгээр л арай ядан оноон тохоож, утгыг илэрхийлж орчуулж байгаа юм шигээр ярилцаж, бичих болж. Энэ нь тийм ч баталгаатай, бодтой тайлбар мөн болов уу?!, аль эсвэл... Баабар, нэгэнтээ “Юм болгон нэртэй” гэдэг судалбартаа: “Даяаршиж, нэг гэрт орж байгаа өнөөгийн ертөнцөд нэгэн утгаар ойлгодог нэртомьёо улам ч ач холбогдолтой болж байна.” (Өдрийн сонин, 2008, № 295) гэж тун ч онож өгүүлсэн бий. Манай монгол хэлний “**даяаршил**”, “**даяарчлал**” гэдэг үг, “**дэлхийчлэл**” гэдэг үгс нь зөөвөрлөж тээвэрлэж байгаа утга, эрчим, ухаарал-мэдээлэл, орон зай, цаг хугацаа, соёлын айн илэрхийлэл талаасаа ч ойролцоодуу үг хэллэг юм. Тийм учраас монгол хэлний эдгээр үгсийн зөөж, тээж байгаа нийт даяарыг хамрах, нэвчих гэсэн утга, мэдээлэл сүлэлдэн, бие биеэ нөхөж болох талтайг үгүйсгэх аргагүй. “Хэл бол алс холын гүрэнд аваачих агт морь юм”. гэсэн Араб ардын цэцэн үг байдаг аж. Монгол хэлний “**даяар**” гэдэг дан үг, “**даяар монгол**” гэдэг нийлэмж үг нь аль тэргээ 12-13-р зууны үед тал хээрийн морьтон монголчуудыг алс Өрнө рүү ч, Дорно руу ч, ерөнхийдөө **дэлхий даяар** сүр хүчээ бүрэн төгс илтгэж, дэлхийн дайдад шудран хүрч, эдийн засаг, оюун санаа, удирдлагын арга ухаан, соёлын “**даяаршил**”-ын торгон замыг эхлүүлж байсныг гэрчилдэг гэж үзэж болмоор байна.